

ЕЛЮЙ ЧУЦАЙ ЧИНГИС ХААНТАЙ АНХ УУЛЗСАН НЬ*Н.Төмөр**

Чингис хааны Алтан улсыг мөхөөх ерөнхий бодлогын нэг хэсэг нь нэгэнт мөхсөн Ляо улсын төрд алба хашиж байсан өндөр албан тушаалтай түшмэд болон нийгмийн нэрт хүмүүсийн Алтан улсын ноёрхолд дургуйцэж байсныг ашиглан тэдгээр хүмүүсийг өөрийн талд татаж ажиллуулах явдал байлаа.

Ляо улсыг мөхөөсний дараа Алтан улсын хаад ноёд ноёрхолоо бэхжүүлэх зорилгоор хятан нарыг гадуурхах бодлогыг улам хүчтэй явуулсны уршгаар хятан нар Алтан улсын эсрэг тэмцэж, энд тэндгүй нэг бус удаа бослого гаргажээ. Алтан улсын хааны ордныхон ч хятан нараас болгоомжилсон арга хэмжээг авч төрийн алба хашиж байсан хятан нарыг зайлуулах бодлого хэрэгжүүлж байсан билээ. Тухайлбал, 1163 онд Алтан улсын хаан, “хятан гаралтай мянгатын ноёдыг халж, тэдний харьяат өрхүүдийг зүрчид гаралтай мянгатын ноёдол захируулах” тухай зарлиг буулгажээ.¹ Чингис хаан Алтан улсын эсрэг дайлахаас өмнө дээрхи бодлогыг эсэргүүцсэн хятан гаралтай олон нэрт хүмүүс Алтан улсаас урваж, Их Монгол улсын талд орж байлаа. Харин Монголын цэрэг Алтан улсын эсрэг байлдах болсноос хойш бүр ч олон хятан хүмүүс Их Монгол улсын талд орох болжээ. Тухайн үед Монгол улсад урван орж ирсэн нэлээд нэрд гарсан хятан нараас Елюй Ахай, Елюй Тухуа, Елюй Люгэ, Шимо Ишин, Шимо Мянганы нарын нэрийг дурдаж болох юм. Тухайлбал, Алтан улсын хойд хязгаарын мянгатын ноён байсан хятан гаралтай Елюй Люгэ /1165-1220/ Алтан улсын эсрэг тэмцэл хийж, 1212 онд Монголын цэрэгтэй хамтран Алтан улсын эсрэг дайн байлдаанд оролцохоор Чингис хаантай хэлэлцээр байгуулжээ.² Хятан нар Их Монгол улсад урван орох болсон бас нэг гол шалтгаан нь Монгол улсын хүчээр Ляо улсын засаг төрийг сэргээн босгож, Алтан улсаас өшөө хонзонгоо авахад оршиж байлаа. Тухайлбал, Шимо Ишин³ 10 настай байхдаа эцгээсээ Алтан улс Ляо улсыг мөхөөсөн тухай сонсож мэдээд ихэд уурлан, “хөвүүн чинь түүнийг /Ляо улсыг/ сэргээн босгож чадна” хэмээн өгүүлжээ.⁴

Монголын цэрэг Алтан улсын нийслэл Чжунду /өнөөгийн Бээжин хот/-г 1215 онд эзэлсэний дараа Чингис хаан урьд өмнө баримтлаж байсан хятан нарыг өөртөө татан ашиглах бодлогыг

*Н. Төмөр – ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

үргэлжлүүлэн, хятаны Ляо улсын сурвалжит Елюй овгийн Елюй Чуцайг өөртөө татан Их Монгол улсын төрийн хэрэгт хүчийг нь дайчлан зүтгүүлжээ.⁵ Чингис хаан Алтан улсыг дайлан 1215 онд Чжунду хотыг эзэлсэн явдал Елюй Чуцайн хувь заяанд ихээхэн өөрчлөлт оруулжээ. Чингис хаан тухайн хүний үндэс угсаа, гарал үүслийг үл харгалзан эрдэм боловсролтой хүнийг ямагт сурвалжлан олж, төрийн албанд ашиглахыг эрмэлздэг байсан учраас Елюй Чуцайг эрдэмтэй хүн хэмээн сонсож мэдээд уулзахыг сонирхжээ. Чингис хаан Елюй Чуцайг Монголд дуудан ирүүлж, шар бар жил буюу 1218 онд Хэрлэн мөрний хөвөөн дэх ордондоо түүнтэй анх удаагаа уулзжээ.⁶ Тэр цагаас эхлэн Монголын их хаан хятаны мэргэн түшмэл хоёрын хооронд ер бусын нөхөрсөг харилцаа тогтов. Елюй Чуцай урт сайхан сахалтай байсан учир түүнийг Чингис хаан нэрээр нь бус “урт сахалт” гэж өхөөрдөн дууддаг байлаа.⁷ Елюй Чуцай хаанд бараалхахад Чингис: “Ляо улс Алтан улсад үеийн үед өшөөтэй билээ. Миний бие чиний өмнөөс өшөөг нэгэнт авлаа.” хэмээн хэлэхэд Елюй Чуцай өгүүлдүүн: “Миний эцэг өвөг дээдэс эртнээс Алтан улсад хүчээ өргөн түшмэл болж явлаа. Эзэндээ өшөө санаж хэрхэн болох билээ!” гэв.⁸ Елюй Чуцайн хэлсэн энэхүү үг нь эзэндээ үнэнч байхыг ямагт дээд зэргээр үнэлдэг Чингис хааны сэтгэлд гүнээ нийцэж, нөхөрлөж болох хүн байна хэмээн өөрийн дэргэд шадар болгон байлгахаар шийджээ.⁹

Чингис хаан Елюй Чуцайг өөрийн дэргэд авч хааны зөвлөх, төлөгч улмаар бичээчийн тушаалд томилон ажиллуулав. Монголтой ойр төрөл угсааны Елюй Чуцайд Чингис хааны дэргэд алба хаахад төдий л хэцүү бус байсан нь мэдээж бөгөөд түүний их мэдлэг боловсролтой, хятад хэл бичиг сайн мэддэг нь Чингис хаанд үлэмж хэрэгтэй байжээ. Чингис хаан 1219-1224 онд Дундад Азийн орнуудын эсрэг баруун зүгийн аян дайнд мордохдоо Елюй Чуцайг дэргэдээ авч явж, түүнд их итгэл найдвар хүлээлгэж байв. Нэг хэсэг үе Елюй Чуцай Дундад Азид хоцорч тэндэхийн засаг захиргааны ажилд оролцож байсан боловч удалгүй Монголд буцан ирж, үндсэндээ Хятадын асуудлыг эрхэлсэн гол түшмэл байлаа.¹⁰

1215 онд Алтан улсын нийслэл Чжунду хот /өнөөгийн Бээжин хот/ Монголын цэрэгт эзлэгдснээс хойш 3 жилийн хугацаанд Елюй Чуцай бурханы шашин шүтэж, шашны ажиллагаанд дагнан оролцож байгаад

¹¹ 1218 онд Чингис хаантай уулзан, улмаар Их Монгол улсын төрд алба хаших болсон нь түүний амьдралд чухал эргэлт болжээ.

Зүүлт, тайлбар:

1. Алтан улсын судар, 6-р дэвтэр.
2. БНМАУ-ын түүх, 1-р боть, УБ., 1966, 229 дэх тал., Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 297 дахь тал.
3. Шимо Ишин /1177-1217/ хятан хүн, 1215 онд Мухулайн удирдсан цэргийн өрлөг жанжин байсан бөгөөд 1217 онд Личжоу хотын тулалдаанд амь үрэгдсэн. Личжоу хот нь өнөөгийн БНХАУ-ын Хэбэй мужийн Ли саний нутаг дэвсгэрт оршиж байсан.
4. Юан улсын судар, 150-р дэвтэр.
5. Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр. Су Тяньцзюе нь 1294-1352 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Юан улсын төрд алба хашиж байгаад Тогоонтөмөр хааны үед 1352 онд Улаан алчууртны бослогыг дарахад дайчлагдаж, дайн байлдааны явцад өвчнөөр нас барсан. Түүний эцэг Су Чжидао /1261-1320/ Их Монгол улсын төрд мөн алба хашиж байсан.
6. IN THE SERVICE OF THE KHAN, Edited by Igor de Rachewiltz, Hok-lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W.Geier., Harrassowitz Verlag, Wiesbaden., 1993, p.140; Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр., Юан улсын судар, 146-р дэвтэр.
7. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 8-р дэвтэр., Юан улсын судар, 146-р дэвтэр.
8. Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр., Дай Юан улсын түүх /Дудан, Өлзий, Саран, Соном нарын орчуулага/, Бээжин, 1987, 53 дахь тал. "Дай Юан улсын түүх" бол Монголын Их Юан улсын түүх юм. Үүнийг хятадын Мин улсын Сун Лян тэргүүтэй түүхчид 1369 онд бичсэн. 210 бүлэг түүхээс Манжийн хаан Абахайн зарилгаар Дудан, Өлзий, Саран, Соном нар арван дөрвөн хааны цадгийг монголоор орчуулсныг ӨМӨЗО-ны "Монгол тулгуур бичгийн цуврал"-аар 1987 онд Бээжинд хэвлүүлжээ.
9. Монголын нууц товчоо /хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр Цэндийн Дамдинсүрэн орчуулав/, УБ., 1957, 170 дахь тал., Юан улсын судар, 146-р дэвтэр., Су Тяньцзюе. Төр улсын зохиолын төрөл анги /Гочао вэньлэй/, 57-р дэвтэр.
10. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, 2, 3, 5, 6, 8, 11, 12-р дэвтэр., Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, тэргүүн дэвтэр., Юан улсын судар, 146-р дэвтэр.
11. Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхэтгэл /Чжанжан цзюйши вэньцзи/, оршил.